ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ҮҮРГИЙН ХОРООНЫ ТАЙЛАН

АЖМХ НЭЗХЭ Бүх гишүүдийн хурал 2025

2025.11.20

АГУУЛГА

I. ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНГҮҮД
II. ФАМ ТУР
III. УУЛЗАЛТ
IV. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

MONGOLIA

· ALWAYS · MOVING ·

I. ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНГҮҮД

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

2025 ОНД ССАЖЗЯ РУУ ЯВУУЛСАН ГАДААД ҮЗЭСГЭЛЭНГИЙН САНАЛ

№	Үзэсгэлэнгийн нэр	Хугацаа	Байршил
	АЗИЙН ЗАХ ЗЭЭЛ		
1.	CITM (China International Travel Mart)	2025.03.24-28	Бээжин, БНХАУ
2.	VITM (Vietnam International Travel Mart)	2025.04.10-13	Ханой, Вьетнам
3.	COTTM (China Outbound Travel & Tourism Market)	2025.04.24-26	Бээжин, БНХАУ
4.	SITF (Seoul International Trade Fair)	2025.06.05-08	Сөүл, БНСУ
5.	Pata Travel Mart	2025.08.27-29	Бангонг, Тайланд
6.	Tourism Expo Japan (JATA)	2025.09.25-28	Осака, Япон
7.	Travel show exhibition	2025.11.07-09	Сөүл, БНСУ
	ЕВРОПЫН ЗАХ ЗЭЭЛ		
8.	FESPO (Ferien-und Sportmesse) Zurich, Switzerland	2025.01.30-02.02	Цюрих, Швейцарь
9.	BIT MILANO (Borsa Internazionale del Turismo Milano)	2025.02 .09-11	Итали Милано
10.	ITB Berlin	2025.03.04-06	Берлин, ХБНГУ
11.	TOP RESA (IFTM-International French Travel Market)	2025.09.23-25	Парис, Франц
12.	WTM (World Travel Market) London	2025.11.04-06	Лондон, ИБУИНВУ
	АМЕРИКИЙН ЗАХ ЗЭЭЛ		
13.	IPW (International Pow Wow) Chicago	2025.06.14-18	Чикаго, АНУ
14.	New York ITS / Las Vegas Travel Agent Forum	2025 оны 10 сард	Лас Вегас, Нью-Йорк, АНУ
	ШИНЭЭР ОРОХ ҮЗЭСГЭЛЭН		
15.	БАЙКАЛ үзэсгэлэн	2025.04.09-11	Эрхүү, ОХУ
16.	OSAKA EXPO JAPAN	2025.04.13-10.13 (6 сар турш)	Осака, Япон
17.	GITF (Guangzhou Internationl Trade Fair)	2025.05.15-17	Гуанжоу, БНХАУ
18	ITB Asia	2025.10.15-17	Сингапур
19	ITF (International Travel Fair) Taipei	2025.11.07-10	Тайпэй, Тайвань

2025 ОНД ССАЖЗЯ РУУ ЯВУУЛСАН “GO MONGOLIA” РӨҮДШОУ САНАЛ

№	Зорилтот улс	Хугацаа (сар)
1.	БНХАУ (Бээжин, Шанхай, Гуанжоу, Хонгконг, Хөүбэй, Хайнань,)	III-V
2.	Вьетнам (Ханой)	III
3.	Тайланд (Фукет)	IV
4.	БНСУ (Сөүл)	IV
5.	Япон (Токио)	IX
6.	Сингапур	III
7.	ХБНГУ (Фрайбург)	III
8.	АНУ (Чикаго, Нью Йорк, Вашингтон)	VI
9.	Турк (Станбул)	XII
10.	Арабын Нэгдсэн Эмират Улс (Дубай)	V

2025 ОНД ОРОЛЦСОН ҮЗЭСГЭЛЭНГҮҮДИЙН ХУВААРЬ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

CALENDAR 2025

JANUARY

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	

FEBRUARY

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	

MARCH

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
30	31					

APRIL

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30			

MAY

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
				1	2	3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31

JUNE

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30					

JULY

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28	29	30	31		

AUGUST

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30
31						

SEPTEMBER

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30				

OCTOBER

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
			1	2	3	4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	

NOVEMBER

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
30						

DECEMBER

SUN	MON	TUE	WED	THU	FRI	SAT
	1	2	3	4	5	6
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30	31			

ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНГҮҮД

Mar 04-06	ITB BERLIN -ХБНГУ, БЕРЛИН
Apr 24-26	COTTM-БНХАУ, БЭЭЖИН
Jun 5-8	SITF- БНСУ, СӨҮЛ
Jun 10-15	LETS TRAVEL-ОХУ, МОСКВА
Sep 23-25	IFTM- БНФУ, ПАРИС
Sep 25-28	TEJ- ЯПОН УЛС, НАГОЯ
Nov 4-6	WTM- АНГЛИ УЛС, ЛОНДОН
Dec 1-5	USTOA-АНУ, ВАШИНГТОН
Dec 19-21	CITM- БНХАУ, ХАЙКОУ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

2024, 2025 ОНЫ ҮЗЭСГЭЛЭН, РӨҮДШОУ ХАРЬЦУУЛАЛТ

Үзэсгэлэн		Рөүдшоу	
2024 он	**2025 он**	**2024 он**	**2025 он**
5	9	4	0

2025 ОНЫ ОНЦЛОГ

- Талбайн хэмжээ томорсон
- Төсвүүд нэмэгдсэн
- Шинээр АНУ-ын зах зээл дээр нэвтрэх оролдлого хийж байгаа

2024, 2025 ОНЫ ҮЗЭСГЭЛЭНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

№	Үзэсгэлэнгийн нэр	Талбайн хэмжээ		Оролцсон байгууллага		Төсөв		Тайлбар
		2024	**2025**	2024	**2025**	2024	**2025**	
1	ITB Berlin	70m2	**100m2**	11	**13**	67,75 сая	**273 сая**	Төсөв нэмэгдсэн, талбайн хэмжээ нэмэгдсэн
2	COTTM	30m2	**60m2**	7	**10**	114 сая	**170 сая**	Талбайн хэмжээ 2 дахин нэмэгдсэн
3	SITF	36m2	**45m2**	11	**9**	60,51	**100 сая**	2025 онд шилдэг тохижилттой бүүтээр шалгарсан
4	Let's Travel	-	**36m2**	-	**4**	-	**80 сая**	2024 онд оролцоогүй
5	Top Resa	-	**16m2**	-	**5**	-	**70 сая**	2024 онд оролцоогүй
6	Tourism Expo Japan	36m2	**54m2**	10	**14**	138,5 сая	**180 сая**	
7	WTM	24m2	**42m2**	9	**10**	192,5 сая	**190 сая**	
8	USTOA	-	**-**	-	**5**	-	**150 сая**	Америкийн ТО-уудын холбооны нэгдсэн хурал
9	CITM	54m2	**60m2**	11	**10-12**	162,68 сая	**187 сая**	
10	FOIRE DU VALAIS	24m2	-	4	**-**	183,356 сая		2025 онд оролцоогүй

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ITB BERLIN
The World's Leading Travel Trade Show®

2025 ОНЫ 03 САРЫН 04-06

БЕРЛИН, ХБНГУ

₮273,000,000
/ССАЖЗЯ БАТЛАГДСАН ТӨСӨВ/

ITB BERLIN 2025 ҮЗЭСГЭЛЭНГИЙН МЭДЭЭЛЭЛ:

ITB Berlin (Internationale Tourismus-Börse Berlin) нь 1966 оноос эхэлж зохион байгуулагдаж ирсэн аялал жуулчлалын дэлхийн хамгийн том үзэсгэлэн. Жар орчим жилийн түүхтэй тус үзэсгэлэнд дэлхийн бүх тивээс мэргэжлийн байгууллагууд буюу мэргэжлийн холбоод, тур операторууд, зочид буудал, авиа компаниуд, тээврийн байгууллагууд, интернет захиалгын компаниуд болоод аялал жуулчлалын чиглэлийн хэвлэл мэдээлийн хэрэгслүүд оролцож аялал жуулчлалын чиг хандлагыг тодорхойлж гэрээ хэлэлцээрүүд хийдгээрээ онцлогтой. Үзэсгэлэнд жилд дунджаар 200 орчим орны 10000 орчим байгууллага талбай авч оролцдог ба зөвхөн мэргэжлийн хүмүүс үзэгчээр оролцдог. Жишээ нь 2023 онд 90.127 мэргэжлийн үзэгч хүрэлцэн ирсэн. 2015 онд Монгол Улс ITB-Berlin -ий түнш орноор оролцож өргөн хүрээтэй арга хэмжээ зохион байгуулсан нь Европ тив төдийгүй дэлхий даяар Монголыг сурталчлах, улмар жуулчдын урсгалыг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр үзүүлсэн болно.

ITB BERLIN 2025 МОНГОЛ УЛСЫН ОРОЛЦОО

ITB Berlin 2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд

АЖМХ-ны нэгдсэн зохион байгуулалт дор Европын зах зээлийн

салбар холбооны 13 ТО-ын төлөөлөл

НАЖГ, Чингис Хаан Үндэсний Музей Go Mongolia үндэсний

брэндийн сурталчилгааны 100м2 талбай авч оролцно.

- ATTA, ITB China, ITB Berlin, National Geographic зэрэг салбарын томоохон төлөөлөлтэй хамтын ажиллагааны уулзалтуудыг зохион байгуулна.
- Монгол улсын соёл урлагийг сурталчилсан, ардын урлагийн тоглолтыг Хаан Найрал Чуулгын уран бүтээлчид толилуулна.
- ITB Berlin 2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр тур оператор компаниуд Монгол Улс руу жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, түнш байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, Европын зах зээлд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг эрэлхийлэн 250 гаруй бизнес уулзалтуудыг зохион байгуулна.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

- 2019 онд Европын орнуудаас нийт 24069 жуулчин Монголд ирж байсан бол энэ тоо Ковидын дараа буюу 2023 онд 16009 болж буурсан. Энэхүү бизнес уулзалтуудын үр дүнд 2025 онд Германаас ирэх жуулчдын тоо 10-25%, Европоос ирэх жуулчдын үзүүлэлт 15-20% нэмэгдэх төлөвтэй харагдаж байна.
- Европ жуулчид нэг удаагийн зардал өндөртэй, холын зайн аяллыг сонирхдог гэдгээрээ алдартай бөгөөд Европ жуулчид Монгол улсад дунджаар 12-14 хоног аялж, тухайн аялалдаа дунджаар 2500- 3500 USD зарцуулдаг тул Монгол улсын эдийн засагт (шууд ба шууд бусаар) валютын орлогыг нэмэгдүүлдэг чухал зах зээл юм.
- Энэхүү үзэсгэлэнд дэлхийн тив бүрээс мэргэжлийнхэн хүрэлцэн ирж оролцдог тул үнэ цэнэтэй бөгөөд Монгол гэсэн нэгдсэн сурталчилгаа явуулдгаараа чухал ач холбогдолтой. Иймд тус үзэсгэлэнд нэгдсэн зохион байгуулалттай оролцдог олон жилийн уламжлалаа хадгалж үргэлжлүүлэх, Монгол улсаа дэлхийн зах зээлд таниулах чухал ач холбогдолтой гэж үзэж байна. 2024 онд Монгол улсад 808,218 жуулчид ирсний 32.6%-ийг буюу 263,479 нь Европын жуулчид байгаа тул энэхүү өсөлтийг дэмжих шаардлагатай

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН ДИЗАЙН, ТОХИЖИЛТЫН ШИЙДЭЛ







MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ОРОЛЦОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, СОНГОСОН АРГАЧЛАЛ

Нийт 23 байгууллага ITB Berlin 2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд тэдгээр байгууллагуудад ITB Berlin үзэсгэлэнгийн ерөнхий танилцуулгыг хийсэн. Тэдгээрээс доорх 13 байгууллага оролцох боломжоо илэрхийлсэн тул оролцуулахаар шийдвэрлэсэн. Эдгээр 13 байгууллагын 5 нь старт-ап буюу гарааны бизнес эрхлэгчид

1. A Star Mongolia LLC
2. Explore Mongolia
3. Golden Gobi
4. Ider Expeditions
5. Amicus
6. Juulchin
7. Tsolmon Travel
8. Duroo Travel
9. Juulchin World Tours
10. Great Genghis tours & expeditions
11. No Na Travel
12. Rara Avis
13. Unlock Steppe Mongolia



ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

GOVERNMENT OF MONGOLIA
MINISTRY OF CULTURE, SPORTS, TOURISM AND YOUTH

ULAANBAATAR CITY TOURISM DEPARTMENT
IMPLEMENTING AGENCY OF THE MAYOR

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА

GOBI

ЧИНГИС ХААН МУЗЕЙ

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

China Outbound Travel & Tourism Market

COTTM 2025

24-26 APRIL

2025 ОНЫ 04 САРЫН 24-26

БЭЭЖИН, БНХАУ

₮170,000,000

/ҮЗЭСГЭЛЭНГИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВ/

COTTM 2025 ҮЗЭСГЭЛЭНГИЙН МЭДЭЭЛЭЛ:

20 жилийн турш салбартаа үйлчилж буй COTTM нь салбарын хамгийн чухал платформ гэж тооцогддог бөгөөд зөвхөн гадагшаа аялал жуулчлалын өсөн нэмэгдэж буй зах зээлд төвлөрсөн БНХАУ дахь цорын ганц **B2B** арга хэмжээ хэвээр байна. 2005 оны 4-р сард анх эхэлснээсээ хойш COTTM нь Хятадын гадагшаа аялал жуулчлалын зах зээлийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж, олон улсын аялал жуулчлалын чиглэлүүд болон аялал жуулчлалын бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг, ялангуяа алслагдсан болон онцгой аяллын чиглэлүүдийг Хятадын аялал жуулчлалын салбартай холбох, хамтын ажиллагаа өрнүүлэх чухал платформыг бүрдүүлж ирсэн.

"COTTM нь Хятадын өсөн нэмэгдэж буй гадагшаа аялал жуулчлалын зах зээлд байнга төвлөрч, Хятадын гадагшаа аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсээр ирсэн."
— Дай Бин, Хятадын Аялал Жуулчлалын Академийн (CTA) Ерөнхийлөгч, Үндэсний Аялал Жуулчлалын Өгөгдлийн Төвийн Захирал

COTTM 2025 ҮЗЭСГЭЛЭНГИЙН ОНЦЛОГ:

COTTM нь дэлхийн аялал жуулчлалын чиглэлүүдийг нэг дор цуглуулж, ялангуяа **"шинэлэг, онцгой, захиалгат"** аялал жуулчлалын бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг, түүнчлэн **"Нэг бүс, Нэг зам"** санаачилгын орнуудын төлөөлөгчдийг нэгтгэдэг.

- **COTTM** үзэсгэлэнд 5,000 гаруй Хятадын аялал жуулчлалын оператор компани оролцдог.
- **COTTM** нь Хятадын тэргүүлэх гадагшаа аялал жуулчлалын операторуудын хүндэтгэл, хүчтэй дэмжлэгийг хүлээсэн арга хэмжээ юм.
- **COTTM** нь **"Нэг бүс, Нэг зам"** санаачилгын үндэсний стратегийг хэрэгжүүлж, 2025 оны **"COTTM Conference"** арга хэмжээний хүрээнд **"Гадагшаа Аялал Жуулчлалын Хөрөнгө Оруулалтын Форум"**-ыг зохион байгуулна. Энэ форум нь хэд хэдэн улсын элчин сайдын яамд, аялал жуулчлалын байгууллагуудыг нэгтгэж, тэдний аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын бодлого, чанартай төсөл, хөгжлийн боломжуудыг танилцуулах болно.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

Хятад жуулчдын аяллын онцлог, эдийн засгийн үр нөлөө
•Хятад жуулчид **багийн аяллыг илүүд үздэг, өндөр зарцуулалттай** байх хандлагатай. Монгол Улсад дунджаар **5-7 хоног** аялж, нийт **3,500-5,000 юань** зарцуулдаг.
•2024 онд Монгол Улсад **808,956 жуулчин** ирсний **28% буюу 221,225 нь Хятад жуулчид** байгаа тул энэ өсөлтийг **тогтвортой нэмэгдүүлэх бодлого баримтлах** шаардлагатай. Үзэсгэлэнгийн үр дүнд энэ тоог **10-20%-иар нэмэгдүүлэх боломжтой**.
•Иймд тус үзэсгэлэнд **нэгдсэн зохион байгуулалттай тогтмол оролцож, Монгол Улсыг Хятадын аялал жуулчлалын зах зээлд илүү өргөн хүрээнд таниулах нь чухал** гэж үзэж байна.

•Хятад бол Монголын аялал жуулчлалын хамгийн том зах зээл тул тусгайлсан маркетинг, сурталчилгааны хөтөлбөр хэрэгжүүлэх нь чухал.
•COTTM үзэсгэлэнд оролцох нь шинэ түншлэл үүсгэж, маркетингийн үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой.
•Хятадын жуулчдад зориулсан аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэх, шинэ чиг хандлагад нийцүүлэх шаардлагатай.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН ДИЗАЙН, ТОХИЖИЛТЫН ШИЙДЭЛ

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ОРОЛЦОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, СОНГОСОН АРГАЧЛАЛ

Нийт 14 байгууллага COTTM 2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд тэдгээр байгууллагуудад COTTM 2025 үзэсгэлэнгийн ерөнхий танилцуулгыг хийсэн. Тэдгээрээс доорх 11 байгууллага оролцох боломжоо илэрхийлсэн бөгөөд дараах байгууллагуудыг оролцуулахаар шийдвэрлэсэн.

1. Shine zuuch travel
2. Eyeland travel
3. AB travel
4. Otgoodor
5. Adventure Mongolia
6. New juulchin tours
7. Active Mongolia
8. GS TOUR
9. HUVSGUL TRAVEL
10. ETU travel

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

GOVERNMENT OF MONGOLIA
MINISTRY OF CULTURE, SPORTS, TOURISM AND YOUTH

ULAANBAATAR CITY TOURISM DEPARTMENT
IMPLEMENTING AGENCY OF THE MAYOR

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА

HUNNU AIR
Wings of Mongolia

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

SITF
Seoul International Travel Fair

“Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо” НЭЗХЭ-Солонгос Зах Зээлийн Салбар болон бусад Холбооноос бүрдсэн 10 байгууллагын 20 төлөөлөл БНСУ ын Сөүл хотноо 2025 оны 06 сарын 05- 08-ны өдрүүдэд зохион байгуулагдах“SEOUL INTERNATIONAL TRAVEL FAIR- 2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улсаа сурталчлан таниулахаар 45м2 талбайг түрээслэн оролцох гэж байна.

2025 ОНЫ 6-р сарын 05-08

СӨҮЛ, БНСУ

₮175,000,000 */ҮЗЭСГЭЛЭНГИЙН ШААРДЛАГАТАЙ ТӨСӨВ/*

₮55,400,000 */ТАЛБАЙН ТҮРЭЭСИЙН ЗАРДАЛ/*

₮119,400,000 */ТОХИЖИЛТ БОЛОН БУСАД ЗАРДАЛ/*

ҮЗЭСГЭЛЭНГИЙН МЭДЭЭЛЭЛ:

1980 оноос хойш сүүлийн 40-д жилийн хугацаанд 40 орны 400 оролцогчид болон 50,000 зочидтойгоор зохион байгуулагдсаар ирсэн. SITF бол Солонгосын олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн хамгийн томоохон нөлөө бүхий арга хэмжээ болдог. Мөн үзэсгэлэнтэй зэрэгцэн 6 сарын 5,6 нд олон улсын аялал жуулчлалын лламны сайд нарын форум болж байгаа бөгөөд энэ жил Монгол улсын сайдыг арга хэмжээндээ урьсан.

2024 он:

- *НИЙТ 42,152 ХҮН ОРОЛЦСОН*
- *780 B2B УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН*

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

- *Уг үзэсгэлэнд Монгол улс тогтмол оролцож ирсэн бөгөөд 10 байгууллага нь 4 хоногийн хугацаанд оролцож нийт 2 өдрийн турш БНСУ болон бусад орны аялал жуулчлалын аж ахуйн нэгжтэй бизнес уулзалт хийгдэнэ. Солонгосын нэр хүндтэй энэхүү үзэсгэлэнд оролцож Монгол Улсын нэр хүндийг БНСУ-д төдийгүй дэлхийн хэмжээнд нэмэгдүүлэхэд сурталчлан, таниулах.*
- *2024 онд Монгол улсад 637,000 орчим жуулчид ирсний 28%-ийг буюу 175,000 орчим нь Солонгос жуулчид байгаа тул энэхүү тоог тогтворжуулан цаашдын өсөлтийг дэмжих шаардлагатай.*

MONGOLIA
ALWAYS · MOVING ·

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

2022 онд 53,382 Солонгос жуулчин 2023 онд 139,512, 2024 онд 175,282 Солонгос жуулчин Монгол улсыг зорин ирсэн. Монгол улсаа сурталчилснаар 2025 оны БНСУ-аас ирэх жуулчдын тоог 20 орчим хувиар нэмэгдүүлж нийт 200,000-д хүргэх зорилттой ажиллаж байна. Солонгос жуулчид хамгийн их ирдэг жуулчид байдаг ба нэг жуулчин дунджаар МУ-д нийт 700-1200 ам.долларыг зарцуулдаг байна. БНСУ-ын жуулчдын дийлэнх нь дунджаар МУ-д 4-7 өдөр аялдаг, өнгөрсөн жил 175,000 орчим доллар оруулсан ба 2025онд 250,000,000 ам.долларын орлого оруулах зорьж байгаа чухал ач холбогдолтой зах зээл юм.

Жуулчдийн тогтвортой өсөлтийг ханган ажиллахын тулд бид SITF-2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн гэх мэт томоохон үзэсгэлэн арга хэмжээнд тогтмол оролцож байх нь чухал ач холбогдолтой байна.

Монгол улсыг Солонгос улсад сурталчлан таниулах, Солонгос улсаас монгол улсад зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, Солонгос зах зээлд ажилладаг тур операторуудын үйл ажиллагааг дэмжих, Монголын үндэсний брэнд бүтээгдэхүүнийг танилцуулах, Монгол соёл урлагыг таниулах, тогтвортой аялал жуучлалыг хөгжүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

.

ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ- А

ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ -Б

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ОРОЛЦОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, СОНГОСОН АРГАЧЛАЛ

Нийт 12 байгууллага SITF 2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд тэдгээр байгууллагуудад COTTM 2025 үзэсгэлэнгийн ерөнхий танилцуулгыг хийсэн. Тэдгээрээс доорх 11 байгууллага оролцох боломжоо илэрхийлсэн тул оролцуулахаар шийдвэрлэсэн.

1. GC Tour Mongolia
2. Mongolian Vision Tours
3. ETU Travel
4. Nomeco
5. Joy Mongolia Travel
6. Let’s Travel
7. IDC Tours
8. Expat Adventure Mongolia
9. Explore Mongolia



MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

INTERNATIONAL TOURISM FORUM
LET'S TRAVEL!

2025 ОНЫ 06 САРЫН 10-15

МОСКВА, ОХУ

₮80,000,000
/ҮЗЭСГЭЛЭНГИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВ/

LET'S TRAVEL 2025 ҮЗЭСГЭЛЭНГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Энэ жил 5 дахь удаагаа ОХУ-ын нийслэл Москва хотод зохион байгуулагдах гэж буй олон улсын аялал жуулчлалын форум Let's Travel-д одоогоор 4 байгууллага оролцох хүсэлтээ илэрхийлээд байна. Нээлттэй бүртгэл 2025 оны 04-р сарыг дуустал үргэлжилнэ. Энэ удаад Монгол улс **24 мкв** иж бүрэн талбайг түрээслэн оролцох болно. Форумын үеэр 6 өдрийн хугацаанд 5 өөр төрлийн арга хэмжээ зохион байгуулагдах юм. Геополитикийн өөрчлөлтийн улмаас Оросын жуулчдын зорин очих боломжит газрууд хязгаарлагдаж буй энэ үед олон улсын шинэ сонголтуудын эрэлт тэдэнд ихсэж байна.

БҮРТГҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД

- Үүтгэл элч
- Хишиг Даймонд
- Хаппи Трип
- Миллениум турс

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

2025 оны 06 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд (6 хоног) ОХУлсын Москва хотноо зохион байгуулагдсан “Путешествуй” олон улсын аялал жуулчлалын форумд Монгол Улсыг төлөөлж ССАЖЗЯ, тур оператор компаниуд болон “Гоёл Кашемир” ХХК амжилттай оролцсон.

Москвад суралцдаг монгол оюутнууд өдөрт 2 удаа 11:30, 17:30 цагуудад урлагийн тоглолтын хөтөлбөр үзүүлж монгол бүжиг, морин хуурын мастер-классыг 4 удаа явуулсан /Морин хуур,хөөмий, уртын дуу, ардын бүжиг/ болно.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

iftm
International & French Travel Market

“Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо” НЭЗХЭ- Европ Зах Зээлийн Салбар Холбооноос 7 байгууллагын 15 төлөөлөл Франц улсын, Парис хотноо 2025 оны 9 сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “IFTM 2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улсаа сурталчлан таниулахаар 16м2 талбайг түрээслэн оролцсон

2025 ОНЫ 9-р сарын 23-25

ПАРИС, ФРАНЦ

₮153,315,000

/ҮЗЭСГЭЛЭНГИЙН ШААРДЛАГАТАЙ ТӨСӨВ/

ҮЗЭСГЭЛЭНГИЙН МЭДЭЭЛЭЛ:

1979 онд анх зохион байгуулагдсан цагаасаа хойш өдгөө IFTM нь Францын бүх аялал жуулчлалын мэргэжилтнүүдийг нэг дор цуглуулдаг цорын ганц B2B үзэсгэлэн юм. Үзэсгэлэнгийн 3 өдөрт 34000 гаруй Франц болон олон улсын мэргэжилтэн, зочид цугладаг ба үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулагддаг олон арга хэмжээ, хурлууд нь мэргэжлийн бүх хүмүүст хамгийн сүүлийн үеийн чиг хандлагыг олж илрүүлэх, салбарын сорилтын талаар ярилцах боломжийг олгодог.

2024 онд:

- *Нийт 31,900 зочин*
- *1,500 байгууллагын, 400 стэнд*
- *13,090 бизнес уулзалтууд*
- *90 хурал зөвлөгөөн*

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

- *2024 онд Монгол улсад 700,000 орчим жуулчид ирсний 32.6%-ийг Европын жуулчид эзэлсэн ба үүнд хамгийн өндөр жуулчны урсгалтай хоёрдох улс Франц байсан тул энэхүү өсөлтийг дэмжих шаардлагатай.*
- *Энэхүү үзэсгэлэн нь франц хэлтнүүдийн зах зээлийн хамгийн ач холбогдолтой, үнэ цэнэтэй үзэсгэлэн бөгөөд тусгай аяллын зах зээлийг хөгжүүлэх, Монгол гэсэн нэгдсэн сурталчилгаа явуулдгаараа чухал ач холбогдолтой.*
- *2025 онд IFTM-д Монгол улс 2019 оноос хойш анх удаа оролцоно*

MONGOLIA
ALWAYS · MOVING ·

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД



Степиндимсе ХХК

ДМД Монгол ХХК

Nomad Planet ХХК

Монгол Талын Мэлмий

Unlock Steppe Mongolia

ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН УРЬДЧИЛСАН ТӨСӨӨЛӨЛ

ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОГЧИД

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

Tourism Expo Japan 2025 Aichi/Central Japan

2025 ОНЫ 09 САРЫН 25-28

АЙЧИ, ЯПОН

₮180,000,000
/ҮЗЭСГЭЛЭНГИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВ/

TEJ 2025 ҮЗЭСГЭЛЭНГИЙН МЭДЭЭЛЭЛ:

TEJ (Tourism EXPO Japan) нь аялал жуулчлалын салбарын дэлхийн хамгийн том арга хэмжээнүүдийн нэг бөгөөд 2014 оноос хойш жил бүр зохион байгуулагдаж байна. Энэхүү арга хэмжээ нь дэлхийн өнцөг булан бүрээс болон Япон улсын дотоодын аялал жуулчлалын бүс нутгуудыг нэг дор цуглуулж, аялал жуулчлалын салбарын шинэ чиг хандлага, боломжуудыг танилцуулдаг. Энэхүү арга хэмжээ нь аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүд, хэвлэл мэдээллийнхэн болон олон нийтэд зориулсан олон төрлийн үйл ажиллагаа, үзэсгэлэн, бизнес уулзалтуудыг багтаадаг. Мөн Япон болон дэлхийн бусад улс орнуудын аялал жуулчлалын бүс нутгуудын соёл, уламжлал, аяллын боломжуудыг танилцуулах зорилготой.

TEJ 2025 ҮЗЭСГЭЛЭНГИЙН ОНЦЛОГ:

- TOURISM EXPO JAPAN нь Ази тивдээ хамгийн том олон улсын үзэсгэлэн бөгөөд аялал жуулчлалын үйлдвэрэлээр Дэлхийдээ томд ордог Япон улсад жил бүр зохион байгуулагддаг юм. Япон улсын аялал жуулчлалын салбар нь Ковидоос хойш жил бүр 20%-30% иар өссөн үзүүлэлттэй явж байгаа бөгөөд Ази төдийгүй дэлхийн олон орны аялал жуулчлалын магнатууд цуглардаг томоохон үзэсгэлэн. Дунджаар жил бүрийн энэхүү ЭКСПО д 150 орны 1400 гаад тур оператор аялал жуулчлалын компаниуд оролцдог ба, олон нийтийн өдрүүдээр 200,000 гаад орчим хүмүүс ирж оролцдог юм. Статистик мэдээллээс харахад TOURISM EXPO JAPAN д Ковидоос хойш буюу 2022 онд 124,000 визитор буюу оролцогч, орон нутгийн 47 байгууллага, 78 орноос 1020 компани буюу байгууллагын төлөөлөл орж байсан бол, 2023 онд 148,000 визитор, орон нутгийн 45 байгууллага, 70 орны 1275 аяллын компаниуд болж өссөн байна. 2024 онд, 182,934 визитор, 80 орны 1400 гаад байгууллага компаниуд оролцсон ба, 5768 бизнес уулзалтууд зохион байгуулагдсан байна.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

- Япон улс нь Монголын аялал жуулчлалын салбарын хувьд стратегийн чухал түнш бөгөөд тогтвортой өсөлттэй, өндөр зарцуулалттай жуулчдын эх үүсвэр юм. EXPO-д оролцсоноор Монголын өвөрмөц соёл, нүүдлийн амьдрал, онгон байгальд суурилсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг Японы зах зээлд шууд сурталчлах, улмаар жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх бодит боломж бүрдэнэ.
- Үзэсгэлэнгийн бизнесийн өдрүүдэд Японы болон бусад улсын аялал жуулчлалын компаниудтай B2B уулзалтууд хийж, шинэ түншлэлүүд байгуулах, хамтран аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэх, шууд нислэгийн чиглэлээр хамтран ажиллах зэрэг бодит үр дүнтэй харилцаа тогтоох боломжтой. Энэ нь Монголын аялал жуулчлалын экспортын чадавхыг нэмэгдүүлэх чухал алхам болно.
- Монгол Улсын аялал жуулчлалын салбарыг олон улсын тавцанд цогцоор нь сурталчлах, “Go Mongolia” үндэсний брэндийн хүрээнд нэгдмэл, цогц дүр төрхийг бий болгох, дэлхийн зах зээлд Монголыг дахин тодотгон таниулах стратегийн чухал боломж юм.

Иймд TEJ 2025-д Монгол Улс амжилттай, үр дүнтэй оролцох нь дотоодын аялал жуулчлалын салбарын хөгжил, олон улсын хамтын ажиллагаа, гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх стратегийн ач холбогдолтой юм.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН УРЬДЧИЛСАН ТӨСӨӨЛӨЛ

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ОРОЛЦОХООР БҮРТГҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД

- Жигүүр
- Sayat Travel LLC
- Ихэр Дэлхий ХХК
- Жамогранд трейвэл ххк
- Амикус
- Алтантур ХХК
- Эвтсан ХХК
- Айрис Тур ХХК
- “Их Хорум” Зочид буудал
- Rara Avis Travel
- Тайгын Цаа ТРЭВЕЛ
- H & A travel transfer connect FILLC
- Женко Тур Бюро ХК
- Хасэбэ интернэшнл ххк
- Стон Түртэл Трэйвэл ХХК
- Зэн Бонсай ХХК
- ITAASMN LLC
- Монстер Трэйвэл
- Let's Travel LLC
- Shine Zuuch Travel
- Nomadic Luujin Tour
- Нутаг Хүнс Трейд
- Erkhet travel
- Түмэн эх чуулга
- Stone Turtle Travel llc
- Занаду Трэйвэл Монгол
- Жаргалтай хос эрдэнэ ХХК
- Анлок Стэп Монголиа ХХК
- Kinsei World LLC
- Зэн Бонсай ХХК /Cozy trip Mongolia/
- И Ти Юу трэвел ХХК
- Шинэ-Амуу ХХК
- New value travel Co.,Ltd
- goldengobi expidetion tour
- И Ти Юу трэвел ХХК
- Erdnat llc
- Андромеда Каяа
- МҮЭХ-ҮҮТӨВ – Alpha Hotel
- Gobi Camel Herd / Camel Track
- ОЧИР АЛТ ХҮҮ ХХК

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

1. Aero Mongolia
2. IRIS TOURS CO.,LTD アイリスツアーズ旅行会社
3. Jiguur
4. ETU Travel Mongolia
5. Amicus Travel Mongolia
6. New Juulchin Tours
7. Flower Hotel Ulaanbaatar
8. Алтантур - Altantour
9. Jamo Grand
10. Monster Travel - Travely
11. H&A Travel
12. Ikh Khorum Hotel
13. Shine Zuuch Travel モンゴル旅行

2025 ОНЫ 11 сарын 04-06

ЛОНДОН, АНГЛИ

₮190,000,000

/ҮЗЭСГЭЛЭНГИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВ/

WORLD TRAVEL MARKET ҮЗЭСГЭЛЭНГИЙН МЭДЭЭЛЭЛ:

1980 оноос хойш сүүлийн 45 жилийн хугацаанд 40 орны 211 оролцогчид болон 9000 зочидтойгоор зохион байгуулагдсаар ирсэн. WTM London бол дэлхийн аялал жуулчлалын худалдааны өлгий нутаг бөгөөд дэлхийн хэмжээнд хамгийн нөлөө бүхий аялал жуулчлалын арга хэмжээ болдог. WTM-2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн нь тогтвортой хөгжил, технологи, инновац сэдвийг онцолсон бөгөөд дэлхийн 184 орны тээвэр, технологи, зочид буудал, тур оператор зэрэг 3,875 үзэсгэлэн гаргагчид оролцож, 29,075 уулзалт зохион байгуулсан ба 43,700+ төлөөлөгч, бизнес эрхлэгчид үзэж сонирхсон нь өмнөх жилээс 7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

WTM- 2025 МОНГОЛ УЛСЫН ОРОЛЦОО

- “World Travel Market- 2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улс 2019 он буюу цар тахлаас хойш 2 дахь удаагаа нэгдсэн зохион байгуулалт дор “GoMongolia” брэндийн сурталчилгааны 52м2 стэнд байгуулан оролцсон,
- 2 эгнээ урагшилсан
- Талбайн хэмжээ 2 дахин нэмэгдсэн давуу талтай
- WTM, BBC Wildlife, NatGeo, ATTA, Wanderlust зэрэг салбарын томоохон төлөөлөлтэй хамтын ажиллагааны уулзалтуудыг зохион байгуулсан,
- WTM- 2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр тур оператор компаниуд Монгол Улс руу жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, түнш байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, Европын зах зээлд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг эрэлхийлэн 250 уулзалтууд хийсэн.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

- *2019 оноос хойш Монгол улс анх удаа WTM 2024 олон улсын аялал үзэсгэлэнд оролцож, оролцогч байгууллагуудын 88.9% нь уг үзэсгэлэнд оролцсон зорилгоо биелүүлсэн. Энэхүү бизнес уулзалтуудын үр дүнд 2025 онд Англиас ирэх жуулчдын тоо 10-25%, Европоос ирэх жуулчдын үзүүлэлт 15-20% нэмэгдэх төлөвтэй харагдаж байна.*
- *Европ жуулчид нэг удаагийн зардал өндөртэй, холын зайн аяллыг сонирхдог гэдгээрээ алдартай бөгөөд Европ жуулчид Монгол улсад дунджаар 12-14 хоног аялж, тухайн аялалдаа дунджаар 2500- 3500 USD зарцуулдаг тул Монгол улсын эдийн засагт (шууд ба шууд бусаар) валютын орлогыг нэмэгдүүлдэг чухал зах зээл юм.*
- *Цаашид World Travel Market хэмээх Европын нэр хүндтэй аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр тогтмол оролцох нь, Монгол улсын нэр хүндийг дэлхийн хэмжээнд сурталчлан таниулах, Европ зах зээлд ажиллаж буй тур оператор байгууллагуудыг идэвхжүүлэх, Европ жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх үр дүнтэй.*
- *2024 онд Монгол улсад 808,218 жуулчид ирсний 32.6%-ийг буюу 263,479 нь Европын жуулчид байгаа тул энэхүү өсөлтийг дэмжих шаардлагатай*

MONGOLIA
ALWAYS · MOVING

ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН УРЬДЧИЛСАН ТӨСӨӨЛӨЛ





MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

Үзэсгэлэнд 17 байгууллага хүсэлтээ илэрхийлснээс дараах 10 байгууллага явахаар болов.

1. Active and Adventure Tours
2. Explore Mongolia
3. Great Chinggis
4. Jamotoraberu
5. New Juulchin Tours
6. Rara Avis Adventure
7. Shine Travel
8. Travel On
9. Tsolmon Travel
10. Zendmen Travel



MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

INTEGRITY IN TOURISM USTOA
United States Tour Operators Association

2025 ОНЫ 12 САРЫН 01-05

АНУ, ВАШИНГТОН

₮150,000,000
/ҮЗЭСГЭЛЭНГИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВ/

USTOA ANNUAL CONFERENCE AND MARKETPLACE

USTOA буюу АНУ-ын Тур Операторуудын Холбоо /АНУТОХ/ 1976 онд байгуулагдсан бөгөөд аялагчдыг хамгаалах фонд буюу 1 сая америк долларын фондод нэгдсэн компаниуд элсэн ордог АНУ-ын аялал жуулчлалын анхны байгууллага юм. Тус холбооны ээлжит хуралдааныг 2025 оны 12 сарын 1-5 өдөр Вашингтон хотноо зохион байгуулна. Ээлжит хуралдаанд жил бүр 700-800 оролцогч ирдэг бөгөөд АНУ-ын аялал жуулчлалын зах зээлд 2024 онд 24,4 тэрбум ам долларын борлуулалт хийсэн гишүүн байгууллагуудын удирдлагууд ирнэ. Америк зах зээлийн салбар холбоо нь тус байгууллагад хамтрагч гишүүнээр элсэн орж байгаа бөгөөд хамтрагч гишүүд нь АНУТОХ-ын идэвхтэй гишүүдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулдаг. Ээлжит хуралд бүртгүүлсэн байгууллага тус бүр АНУТОХ-ын идэвхтэй гишүүдтэй уулзах 11 минутын уулзалт товлоно.

Яагаад тус хуралдааныг сонгосон бэ?

- АНУ-ын аялал жуулчлалын зах зээл Европ, Азийн хөгжилтэй орнуудтай харьцуулахад глобал түвшний том компаниудын нөлөөлөл их, бие даасан агентуудын хөгжил сул, олон муж дамжиж улс орон даяар мэдээлэл, сурталчилгаа хүргэхэд маш төвөгтэй байдаг онцлогтой.
- Иймд тур оператороор дамжин аялдаг жуулчдын зах зээлийг хяналтдаа авсан томоохон байгууллагууд руу чиглэсэн шууд маркетингаар дамжуулан GoMongolia брэндийг сурталчлах шаардлагатай байна. Учир нь энэ компаниудын борлуулалт руу чиглэсэн сурталчилгааны түвшинд бид өрсөлдөх боломжгүй, шаардлагагүй байгаа юм.

ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН ДИЗАЙН, ТОХИЖИЛТЫН ШИЙДЭЛ

MONGOLIA
· ALWAYS · MOVING ·

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

1. **Explore Mongolia**
2. **Selena Travel**
3. **Premium Travel**
4. **Travel buddies**
5. **World Summit**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ХЭМЖИХ:

Үзэсгэлэнгийн үр дүнг шууд борлуулалт ба хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацсан мэдээллээр дүгнэнэ. Тухайлбал:

1. Өглөөний цайнд бүртгүүлж оролцсон зочдын холбогдох хаяг, имэйл
2. Оролцсон тур операторын USTOA үндсэн гишүүнтэй байгуулсан гэрээний нийт мөнгөн дүнгээр,
3. Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд цацагдсан мэдээллийн эх сурвалжаар /АМТА тус мэдээллийг цуглуулах ажлыг хариуцна/
4. АНУ болон бусад улсыг төлөөлөн оролцож буй төрийн бус байгууллага, аялал жуулчлалын төрийн удирдах байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагааны цар хүрээгээр дүгнэнэ. /АМТА хариуцна.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

中国国际旅游交易会
China International Travel Mart

2025 ОНЫ 12-р сарын 19-21

БНХАУ, ХАЙНАН АРАЛ ХАЙКОУ ХОТ

₮187,000,000

/ҮЗЭСГЭЛЭНГИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВ/

БНХАУ-ын хамгийн том аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүдийн бизнес уулзалтад зориулагдсан үзэсгэлэн. Тус үзэсгэлэнд нийт 5,000 гаруй БНХАУ-ын ОУ-ын аялал жуулчлалын тур оператор компаниуд оролцдог бөгөөд дэлхийн аялал жуулчлалын салбарынханд (Хятадын "Бүс ба Зам"-ын орнуудад) хамгийн шинэлэг аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулдаг онцлогтой.

ҮЗЭСГЭЛЭНГИЙН МЭДЭЭЛЭЛ:

БНХАУ-ын олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн (CITM) нь хятадын төрийн зөвлөлөөс зөвшөөрөгдсөн анхны олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн бөгөөд ази дах хамгийн том үзэсгэлэн юм. 2001 оноос хойш жил бүр Шанхай, Куньмин хотод ээлжлэн зохион байгуулагддаг. аялал жуулчлалын байгууллага, аялал жуулчлалын агентлаг, зочид буудал, агаарын тээврийн компаниуд, соёлын байгууллагууд, музей болон бусад соёл, аялал жуулчлалын бизнес эрхлэгчид оролцдог. үүнд хятадын 31 муж, хотын захиргаа, өөртөө засах муж, хонконг, макао, тайвань зэрэг дэлхийн 100 гаруй улс орны аялал жуулчлалын төлөөлөл оролцоно.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:

2024 оны 12-р сард зохион байгуулагдах CITM /CHINA INTERNATIONAL TRAVEL MART/ үзэсгэлэнд амжилттай оролцож үндсэн павилон болон үзэсгэлэнгийн ерөнхий тайз дээр тогтмол өдөрт 2-3 удаа тоглолт хийж, эвент арга хэмжээ, хөгжөөнт тоглоом явуулж, жигд хувцаслан, үндэсний хувцасаараа бүгд ижилсэж, хамгийн үр дүнтэй шийдэлтэй павилон тохижилтыг хийж чадвал бид илүү сайн Монгол улсыг сурталчлах боломжтой.

MONGOLIA · ALWAYS · MOVING ·

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ОРОЛЦОХООР БҮРТГҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД

Одоогийн байдлаар дараах байгууллагууд оролцохоор бүртгүүлсэн ба үзэсгэлэнд 10-12 байгууллага оролцуулна.

1. Horseback Adventure Mongolia ХХК
2. И Ти Юу Трэвел ХХК
3. Шинэ Соёл Тэлмэн ХХК
4. Эй Би Трэйвэл ХХК
5. Ханомаро Тур ХХК
6. Жинчин Кюүн Турс ХХК
7. Хишиг Даймонд ХХК
8. Юу Эн Ий Тулга ХХК
9. Хиад Групп ХХК
10. Унаган Халиун ХХК
11. A Star Mongolia ХХК
12. Номад Планет ХХК
13. Chinggis Travel Group
14. Монгол Тур ХХК



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

MONGOLIA

· ALWAYS · MOVING ·

II. ФАМ ТУР

УНГАР УЛСЫН БУДАПЕШТ ХОТНОО БОЛСОН РӨҮДШОУ

Монгол Улс болон Унгар Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд "Улаанбаатарын Соёлын Өдрүүд" арга хэмжээ 2025 оны 5 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Унгар улсын нийслэл Будапешт хотын Маргарет арал дээр боллоо. Тус арга хэмжээнд Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо – Нийтийн Эрх Зүйн Хуулийн Этгээдийн Европ Зах Зээлийн Салбар Холбооны 8 гишүүн тур оператор компани оролцож байна.

2025 ОНЫ 5-р сарын 10-11

УНГАР, БУДАПЕШТ ХОТ

Аяллын ерөнхий зохион байгуулагч

- Грейт Чингис Экспедишнс ХХК
- Цолмон Трэйвел ХХК
- Нона Трэйвел ХХК
- Степпе Монголиа ХХК
- Блью тур
- Травел Он ХХК
- Идэр экспедишнс
- Миллениум турс

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

Benoit Tredez нь Францын аялал жуулчлалын салбарын туршлагатай мэргэжилтэн бөгөөд Trecom Tourisme компанийн үүсгэн байгуулагч, захирал юм. Тэрээр франц хэлтэн улс орнуудын аяллын агентуудыг холбосон Trecom платформоор дамжуулан олон улсын аяллын бүтээгдэхүүнийг сурталчилдаг. Мөн аяллын нийтлэл, видео контент бүтээж YouTube, LaQuotidienne.fr зэрэг сувгаар түгээдэг. 2025 онд Монголд зочилж, аяллын бүтээгдэхүүнүүдийг сурталчлах, мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх зорилгоор танилцах аялал хийхээр төлөвлөж байна.

ЗОРИЛГО:
Францын аялал жуулчлалын мэргэжилтэн Benoit Tredez Монгол Улсад 2025 оны 8-р сард зочлон, Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, бодлогыг сурталчлах, контент бүтээж Франц хэлтэн зах зээлд түгээх зорилготой.

ОРОЛЦОГЧИД:
•Benoit Tredez (Trecom, Tutos Voyage)
•Théo Tredez
•Танилцах аялал: 2025.08.02–08.18
•Сурталчилгааны суваг: LinkedIn (21,000+ дагагч), Facebook, YouTube, TourMag.fr, WhatsApp, email campaign (20,450+ хүлээн авагч)

ХҮРЭХ ҮР ДҮН:
•Монгол руу багц аялал санал болгодог Францын операторын тоог 50 → 100 болгох
•Франц жуулчдын тоог 6,056 → 12,000 болгох
•Франц зах зээлээс ₮6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олох боломж
•Монголыг “тогтвортой аяллын” чиглэлээр сурталчлах, Travel Life, ATES зэрэг байгууллагуудаар дамжуулан хүлээн зөвшөөрөгдөх

ТАНИЛЦУУЛАХ СУВГУУД:
•Видео (3–5 мин × 12): YouTube, Trotters TV, LinkedIn
•Нийтлэл: TourMag, La Quotidienne du Tourisme
•Мэйл, WhatsApp маркетинг: 20,450 мэргэжилтэн

2025 ОНЫ 08 САРЫН 02-18

₮48,300,000
/ФАМ ТУР төсөв/

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

MONGOLIA

· ALWAYS · MOVING ·

III. УУЛЗАЛТ

ФРАНЦ УЛСЫН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗАВ

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дэд ерөнхийлөгч В.Батзориг, Гадаад харилцааны менежер Ш.Анхбаяр нар Францын аялал жуулчлалын маркетингийн мэргэжилтэн, Trecom болон Tutos Voyage агентлагийн төлөөлөгч Бенуа Тредезтэй уулзалт хийлээ.
Уулзалтын хүрээнд 2025 оны 8 дугаар сард хэрэгжүүлэх “Go Mongolia from France” танилцах аяллын төслийг Бенуа Тредез Монголд өөрийн багийн хамтаар хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Тус аяллын үеэр Монголын соёл, түүх, байгаль, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар фото, видео контент болон мэргэжлийн нийтлэлүүдийг бэлтгэн Франц болон франц хэлтэн орнуудын аялал жуулчлалын салбарын 20,000 гаруй мэргэжилтнүүдэд хүргэх юм.

Дэмжигч байгууллага:

- Блю Мон групп
- МИАТ ТӨХК
- Гайхамшигт Говь АЖХ
- Эрдэнэ ухаа жуулчны бааз
- Говь мираж жуулчны бааз
- Говь кравансерай
- Женко тур
- Нислэг төв
- Чингис хааны музей
- Ханбогд жуулчны бааз
- Бүүвэйт жуулчны бааз
- Грийн Гоби зочид буудал
- Улаанбаатар цирк

БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ФАМ ТУР

Монголд зочлох жилийн хүрээнд Бүгд Найрамдах Польш Улсын жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Польш Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамтай хамтран Польш Улсын аялал жуулчлалын байгууллага, нөлөөлөгчид бүхий төлөөлөгчдөд Монгол Улсыг сурталчлах “Фам тур” арга хэмжээг 2025 оны 9 дүгээр сарын 4-11-ний өдрүүдэд зохион байгуулахаар ажиллаж байна.БНПУ-ын аялал жуулчлалын салбарын төлөөлөгчдөд зориулсан “Фам тур” арга хэмжээ 2025 оны 9 дүгээр сарын 4-11-ний өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулагдав. Тус ажлын хүрээнд ССАЖЗ-ын Сайд Ч.Ундрам, Монгол Улсаас Бүгд найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Н.Оюундарь, Сайдын аялал жуулчлалын асуудал хариуцсан Зөвлөх Б.Золбадрал, ССАЖЗЯ-ны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга В.Батчимэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Зах зээл хариуцсан Дэд ерөнхийлөгч В.Батзориг нар хүлээн авч уулзлаа.

Аяллын ерөнхий зохион байгуулагч

- Нью жуулчин турс ХХК
- Цолмон трэйвел ХХК
- А стар Монголиа ХХК
- Хишиг даймонд ХХК
- Блью тур
- Травел Он ХХК
- Миллениум турс
- Грейт Чингис Экспедишнс ХХК



БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС БОЛОН МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КОМПАНИУДЫН B2B УУЛЗАЛТ

Польшийн аялал жуулчлал, хэвлэл мэдээлэл, соёл, урлагийн салбарын төлөөлөгчид болох TTG Polska, Варшавын Худалдааны танхимын ерөнхийлөгч Марек Трачик, “Itaka” компанийн дэд захирал Катажина Банковска, захирал Ярослав Брониш, “Rainbow” компанийн төслийн ахлах менежер Магдалена Дибчинска, “Nekera” компанийн ерөнхийлөгч Мачай Некиел, „National Geographic Traveller” сэтгүүлийн Ерөнхий редакторын орлогч, “Kaleidoscope” LOT Polish Airlines In-flight сэтгүүлийн ерөнхий редактор Агнешка Франус, ПР менежер Оливьер Даниел Халаса, “ИНТИМАТЕС TEAM”-ийн гүйцэтгэх захирал Катажина Пышиньска, инфлюенсер, жүжигчин Үршула Дебска бөгөөд Польш Улсад алдартай жүжигчин, инфлюенсер Ж.Мишээл нар оролцлоо.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

АТТА-ТАЙ ХАМТРАН СУРГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАВ

"Adventure Travel Trade Association" (ATTA) Монгол улстай хамтран 2025 онд хэрэгжүүлэх боломжит үйл ажиллагааны саналыг Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ажлын алба, Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо, АЖМХ-ны салбар холбоо болох Адал явдалт аялал жуулчлалын холбооны төлөөлөл хэлэлцэж хамтран ажлын хэсэг байгуулан хэрэгжүүлэхээр болсон ба 2025 оны төсвийн тодотголоос шалтгаалан тус сургалт 2026 онд болохоор хойшилсон бөгөөд WTM-2025 үзэсгэлэнгийн үеэр ATTA-н төлөөлөгч Николастай АЖМХ-ны гадаад харилцаа, эвент хариуцсан менежер М.Мөнхжаргал уулзаж дараа жилийн сургалтын талаар ярилцав.

“НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ /NUBIA/-ТАЙ ХАМТРАХ УУЛЗАЛТ

Уулзалтад Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Зах зээл хариуцсан Дэд ерөнхийлөгч В.Батзориг, Удирдах зөвлөлийн гишүүн Т.Лхам-Эрдэнэ, Гадаад харилцааны менежер Ш.Анхбаяр, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт /NUBIA” компанийн Хэрэглэгчийн харилцаа хариуцсан мэргэжилтэн Г.Номин, Чиглэл хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн Г.Тэмүүлэн нар оролцов.

ЯПОН УЛСЫН ЯАМАГАТА МУЖ РУУ АЯЛЛЫН ШИНЭ МАРШРУТ ГАРГАХАД ХАМТРАН АЖИЛЛАНА

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Зах зээл хариуцсан Дэд ерөнхийлөгч В.Батзориг Япон Улсын Яамагата мужийн Захирагч Миэко Ёшимүраг албаны хүмүүсийн хамт хүлээн авч уулзав. Тус муж нь аялал жуулчлалын таатай бүс бөгөөд Монгол Улсаас жуулчин хүлээн авах хүсэлт тавив.

2025 оны 11 сарын 5-ны өдөр WTM-2025 Лондонгийн үзэсгэлэнд Ямагата мужийн Аялал жуулчлал, соёл, спортын хэлтэсийн ОУ-ын аялал жуулчлалын салбар хариуцсан менежер ноён Хосояа Жүничитэй АЖМА-ны Гадаад харилцааны менежер М.Мөнхжаргал болон аялал жуулчлалын Нью жуулчин турс компаний захирал Д.Наранцэцэгтэй уулзаж чартер нислэг хийх боломжийн талаар ярилцан мэдээлэл солилцов.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

БНСУ-ЫН ХАН-АМ ДҮҮРЭГТЭЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАЛ

БНСУ-ын Бусан хотын харьяа Хан-Ам дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчид Монгол Улсад 9 дүгээр сарын 3-7-ны өдрүүдэд албан ажлаар ирсэн ба уг ажлын хүрээнд АЖМХ-ны Солонгос зах зээлийн салбар холбоо буюу МОКТА-ны Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Мягмарсүрэн, А.Батхүү нар хүлээн авч уулзав. Манай иргэдийн хувьд Солонгос улс руу эрүүл мэндийн аялал их хийдэг ба энэ төрлийн аялалд хамтран ажиллах боломж бий. Ингэхдээ хоёр талаас fam tour/танилцах аялал хийж Монгол, Солонгосын аялал жуулчлалын салбарт аяллын шинэ жим гаргахад боломжгүй зүйл биш гэдгийг онцлов.

ТАНСАГ ЗЭРЭГЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛД ХАМТРАН АЖИЛЛАХ УУЛЗАЛТ

БНСУ-ын Incheon хотын “Paradise City Hotel Resort”-ын төлөөлөл Монгол Улсад анх удаа ирж ирж байгаа ба Солонгос зах зээлийн “МОКТА” холбоо, “Dream Travel” компанийн удирдлагууд хүлээн авч гурван талт уулзалтыг /2025.08.07/ хийв. Paradise City Hotel Resort”-ын Ерөнхийлөгч Чой Жон Хван:Тансаг зэрэглэлийн амралт, эрүүл мэндийн аялал, казино, соёлын хөтөлбөрүүдийг цогц байдлаар санал болгож байгаа ба нислэгтэй хосолсон аялал, хамтарсан багц бүтээгдэхүүн гаргах боломжийг тодотгож, хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлэв. Уулзалтад Монголын талаас Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Г.Лхам-Эрдэнэ, Б.Барсболд, МОКТА холбооны тэргүүн Э. Наранхүү, Солонгосын талаас Paradise City Hotel Resort -н Ерөнхийлөгч Чой Жон Хван, Paradise city Казино хариуцсан Гүйцэтгэх захирал Ли Жон Ёон, Маркетинг борлуулалтын албаны Гүйцэтгэх захирал Ким, Жа Хван, Казиногийн Маркетинг борлуулалтын албаны гүйцэтгэх захирал Ко Сэүн Чан, Борлуулалт хариуцсан захирал Ёом Жи Хван, Группийн менежер Ли Сан Хэин нар оролцлоо.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

УЛААНБААТАР - ОРДОС ЧИГЛЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ТОГТВОРЖУУЛАХ ХАМТАРСАН УУЛЗАЛТ

БНХАУ-ын томоохон агаарын тээвэрлэгч компаниудын нэг болох CHINA UNITED нь Улаанбаатар - Ордос чиглэлд 7 өнгөрсөн сарын 18 нд анхны нислэгээ амжилттай эхлүүлсэн билээ.
Тус компанийн зүгээс 186 хүний суудалтай агаарын хөлгөөр батлагдсан хуваарийн дагуу буюу даваа, баасан, ням гарагуудад нислэг гүйцэтгэж байгаа юм. Энэ талын хамтын ажиллагааны хүрээнд хятад зах зээл дээр ажилладаг Монголын тур оператор компаниудын төлөөлөлтэй 8 сарын 01 ний өдөр уулзав.

ЯПОНД АЛБАН ЁСНЫ ТӨЛӨӨЛӨГЧТЭЙ БОЛОВ

АЖМХ нь нь Японы Star Platina, Inc. компанийн бизнес продюсер Рюүгэн Доко (Такехиса)-г тус байгууллагын Япон дахь албан ёсны төлөөлөгчөөр томиллоо. Энэхүү гэрчилгээг гардуулах уулзалтад Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо (АЖМХ)-оос дэд ерөнхийлөгч В.Батзориг, дэд ерөнхийлөгч Э.Тэнгисболд нар оролцлоо.

Такехиса нь аялал жуулчлалын салбарын өргөн хүрээтэй туршлагатай бизнес эрхлэгч бөгөөд Японы зах зээлд Монгол Улсыг аялал жуулчлалын өвөрмөц, сонирхол татахуйц чиглэл болгон сурталчлах, Японоос Монголд аялах жуулчдын тоо өсгөх, түүнчлэн хоёр орны хамтын ажиллагааг бэхжүүлэх хөрөнгө оруулалтын гүүр болох зорилготой ажиллах юм.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

БНХАУ-ЫН ЭРЭЭН ХОТЫН СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН КОРПОРАЦИЙН ТӨЛӨӨЛӨЛ ХҮРЭЛЦЭН ИРЭВ

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны урилгаар БНХАУ-ын Эрээн хотын Соёл, Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын корпорацийн төлөөлөл хүрэлцэн ирэв. Хил орчмын аялал жуулчлалыг эрчимжүүлэх зорилт, агуулгын хүрээнд уулзалт боллоо.
Эрээн хотын Эрээн хотын соёл, аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын корпорацийн ерөнхийлөгч Ван Лихуа: Эрээн-Улаанбаатар хот хооронд нислэг эхлэх гэж байгаа, Бүлэг жуулчдын өдрийн визний асуудлыг хөнгөлөх боломж болон Цахим визний бэрхшээлийн тухай мэдээлэл өгч санал солилцов.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ХЯТАДЫН 10 ХОТООР БИЗНЕС АЯЛАЛ ХИЙГЭЭД ИРСЭН АЯЛЛЫН БАГИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

БНХАУ-ын 10 хотоор 28 хоногт нийт 5200 км замыг авто машинаар туулан Go Mongolia болон Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах зорилгоор Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, АЖМХ - Хятад зах зээлийн салбар холбоо-ны гишүүн байгууллагууд болох AKU Game World, Marco Polo Tour-н төлөөлөл амжилттай яваад ирсэн билээ.

ЯПОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨХ ТАКЕХИСА ДОКОТОЙ САНАЛ СОЛИЛЦОВ

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны НЭЗХЭ-ийн дэд ерөнхийлөгч В.Батзориг, Япон улсын иргэн Такехиса Докотой уулзаж, Монголын аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах боломж, хөрөнгө оруулалт татах чиглэл, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн талаар санал солилцлоо. Ноён Такехиса Доко цаашид Монгол Улсыг Японы жуулчдад илүү таниулах, хоёр орны аялал жуулчлалын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөн олон улсын тавцанд Монголын имиджийг өргөхөд идэвхтэй оролцохоо илэрхийлжээ.

MONGOLIA TOURISM ORGANIZATION
Legal entities of public law

ӨМӨЗӨ-НЫ ХЯНГАН АЙМАГТ ХЯТАД-МОНГОЛ, ОХУ-ЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН АНХДУГААР УУЛЗАЛТ БОЛОВ

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хянган аймгийн Улаан хотноо Хятад-Монгол, Хятад-ОХУ-ын бизнес эрхлэгчдийн анхдугаар уулзалт амжилттай зохион байгуулагдлаа.
Уулзалтын үеэр Хянган аймгийн Гадаад харилцааны алба болон Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо (АЖМХ) хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд энэхүү санамж бичгийн хүрээнд ирэх хоёр жилийн хугацаанд хил дамнасан аялал жуулчлал, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцлоо.
Мөн энэ үеэр гурван улсын импорт, экспорт, аялал жуулчлалын хамтын ажиллагааны нийгэмлэгийг албан ёсоор байгуулж, АЖМХ-НЭЗХЭ-ийн дэд ерөнхийлөгч В. Батзоригийг аялал жуулчлалын зөвлөхөөр томилсон байна.

МИЦҮБИШИ КОРПОРАЦИТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ ТАЛААР ХЭЛЭЛЦЭВ

АЖМХ-НЭЗХЭ, Мицүбиши корпорацийн төлөөлөлтэй уулзаж Монголын аялал жуулчлалыг сурталчлах, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар ярилцлаа.

Уулзалтад Шинэ Улаанбаатар Олон Улсын Нисэх Онгоцны Буудлын хувьцааг хамтран эзэмшигч Мицүбиши корпорацийн Улаанбаатар хот дахь оффисын Ерөнхий менежер Футоши Сузуки тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоог төлөөлөн Дэд ерөнхийлөгч В.Батзориг, Э.Тэнгисболд, Ажлын албаны гадаад харилцааны менежер Ш.Анхбаяр нар оролцов.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

Холбогдох дугаар:- 7712 8822
Мэйл хаяг:- expo@mto.mn
Вэб сайт:- www.mto.mn